



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.05.09 № 161
танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗАРТ**

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт үр дүнд”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.НАРМАНДАХ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит

АГГ-2022/20-ШТА-ГА



Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон үр дүнгийн судалгааг тодорхой давтамжтайгаар үр дүнтэй зохион байгуулах замаар хэрэглэгчдийг бодит мэдээллээр хангаагүй байна.

Орхон аймаг
2021 он

Агуулга

Аудитыг гүйцэтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	1
Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл, үндсэн мэдээлэл.	2
Ахлах аудитор: Б.Буян-Ундрах	БҮЛЭГ 1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан хэдий ч хэрэгжилтийг бодитой үнэлээгүй, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тооцож чадаагүй байна.	4
Аудитор: Т.Болормаа Д.Цогбадрах	1.1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан боловч хэрэгжилтийг бодитой үнэлээгүй байна.	4
2022 оны 05 дугаар сар	1.1.2 Орхон аймгийн иргэд, ААН-үүдийг зах зээлд эрэлттэй болон илүүдэлтэй мэргэжлийн талаарх мэдээллээр бүрэн хангаж чадаагүй байна.	6
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70357955, 70350757 дугаарын утас, 70359826 дугаарын факсаар харилцана уу.	1.1.3 Орон нутагт бодлогын баримт бичгийг боловсруулахад бүх талуудын оролцоог хангасан байна.	7
Уг тайланг УАГ-ын веб сайтаас үзнэ үү. www.audit.mn	БҮЛЭГ 1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.	8
Хаяг: Орхон аймаг дахь Төрийн аудитын газар	1.2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүгийн тооцоолол хийгдээгүй байна.	8
Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон	1.2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.	8
	1.2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг хуваарилсан байна.	8
	БҮЛЭГ 1.3 Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох үйл ажиллагаа хоорондоо уялдаагүй байна.	9
	1.3.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө уялддаг ч мэдээлэл солилцох үйл ажиллагаа хангалтгүй байна.	9
	1.3.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэг өрх-нэг ажлын байр хөтөлбөрийг хэрэгжүүлсэн боловч итгэлийн зээлийн үр дүнд хэдэн ажлын байр нэмэгдсэн нь тодорхойгүй байна.	11
	1.3.3 Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь хууль, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлсэн байна.	11
	1.3.4 Хагас бүтэн жилээр дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хийгддэг боловч өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож, баримтжуулаагүй байна.	15
	БҮЛЭГ 2.1 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааг үр нөлөөтэй, хэмнэлттэй зохион байгуулсан байна.	16
	2.1.1 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлөөс ирүүлсэн квотыг хангасан байна.	16
	2.1.2 Орхон аймгийн иргэд, ААН-үүдийг зах зээлд эрэлттэй болон илүүдэлтэй мэргэжлийн талаарх мэдээллээр бүрэн хангаж чадаагүй байна.	18
	2.1.3 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд баталсан хөрөнгийг хэмнэлттэй зарцуулжээ.	19

БҮЛЭГ 2.2 Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад, дотоодын зээл, тусламж, ОУБ-уудын санхүүжилттэй төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна.	21
2.2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, чиглэлээр гадаад болон дотоодын зээл, тусламж, олон улсын байгууллагуудын санхүүжилттэй төсөл, хөтөлбөр Орхон аймагт хэрэгжээгүй байна.	21
2.2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлөөс эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлээгүй, хөдөлмөрийн зах зээлийн ажил хайгч, ажилд зуучлуулсан иргэд болон бизнесийн гарааны дэмжлэгийн 60 орчим хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.	21
БҮЛЭГ 2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлсэн, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн дүнд иргэдийн амьдрал дээшилж байгаа нь тодорхойгүй, зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.	23
2.3.1 ХЭДС-ийн орлогыг хуульд заасны дагуу бүрэн төвлөрүүлсэн байна.	23
2.3.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан боловч хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн дүнд иргэдийн амьдрал дээшилж байгаа нь тодорхойгүй, зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.	24
БҮЛЭГ 2.4 МБСДС-аас сурагчдад сар бүр олгох тэтгэлгийн хэмжээг 200.0 мянган төгрөг болгосноор суралцагчдын тоо нэмэгдсэн ч ажил эрхлэлтийн байдал хангалттай түвшинд хүрээгүй байна.	26
2.4.1 Сурагчдад сар бүр олгох тэтгэлгийн хэмжээг 200.0 мянган төгрөг болгосноор сурагчдын тоо нэмэгдсэн байна.	26
2.4.2 МСҮТ-үүдийг 2016-2022 оны хооронд суралцаж төгссөн нийт сурагчдын 58.3 хувь, насанд хүрэгчдийн 83.5 хувь нь хөдөлмөр эрхэлж байна.	26
БҮЛЭГ 2.5 "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дүгнэх хугацаа хараахан болоогүй байна.	28
2.5.1 Цар тахлын үед ажлын байрыг хадгалах талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь үр дүнтэй хэрэгжсэн эсэхийг дүгнэх хугацаа хараахан болоогүй байна.	28
2.5.2 Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс 4,607 даатгуулагчид тус бүр нь 200.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.	30
2.5.3 Цар тахлын үед сайн дурын даатгалд хамрагдагсдын тоо өссөн байна.	30
Аудитын дүгнэлт	32
Аудитын зөвлөмж	33



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 1/06

Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх”-ийн 2.4 дэх хэсэг, “Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлсүгэй.

4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2022 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Д.Мөнхбат/, аймгийн Засаг дарга /С.Батжаргал/, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга /Х.Эрдэнэбат/ нарт зөвлөсүгэй.

5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг ахлах аудитор Б.Буян-Ундрах, аудитор Т.Болормаа, Д.Цогбадрах нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол улс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ААН	Аж ахуйн нэгж
ХХҮГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төв
ЦТҮААЭСХ	Цар тахлын үеийн аж ахуй эрхлэлтийг сэргээх хөтөлбөр
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ЗХЭДХ	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэнэ.

Уг зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийгдлээ. Үүнд:

- Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг мөн Төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа;
- Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгасан төсөл, хөтөлбөр зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл, сумын хөдөлмөр эрхлэлтийн ажилтан /хөдөлмөрийн алба/, хөдөлмөрийн биржийн 2016-2021 оны үйл ажиллагааг хамруулан Орхон аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС-300, 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтуудыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг аудитын арга зүйг ашиглалаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудиттай холбоотой дараах хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

Хууль:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 3-20 дугаар зүйлд; /2015 он/
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 3-6, 8-21, 24 дүгээр зүйл; /2020 он/

- Төсвийн тухай хууль; /2011 он/
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 4-26 дугаар зүйл; /2011 он/
- Монгол Улсын 2017-2021 оны төсвийн тухай хууль;
- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;

Улсын Их Хурлын тогтоол:

- 2016 оны 19 дүгээр тогтоол “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”;
- 2016 оны 350 дугаар тогтоол “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”;
- 2020 оны 52 дугаар тогтоол “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг;
- 2001 оны 57 дугаар тогтоол “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”;

Засгийн газрын тогтоол:

- 2021 оны 119 дүгээр тогтоол “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”;
- 2011 оны 375 дугаар тогтоол “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”;
- 2016 оны 276 дугаар тогтоол “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”;

Аудит хийж гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Нармандах хянан удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж, ахлах аудитор Б.Буян-Ундрах, аудитор Т.Болормаа, Д.Цогбадрах нар хийж гүйцэтгэв.

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа:

Аудитын талбарын ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн, тайланг 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор үе шатны хяналтаар оруулан, Тэргүүлэх аудитораар баталгаажуулж, 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн дотор УАГ болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

**Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар**

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, Төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх:

Бүлэг 1

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийг бодитой үнэлээгүй, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн хэрэгцээг тооцоогүй, төрийн байгууллагын мэдээлэл солилцох үйл ажиллагаа уялдаагүй байна.

1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан хэдий ч хэрэгжилтийг бодитой үнэлээгүй, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тооцож чадаагүй байна.

1.1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан боловч хэрэгжилтийг бодитой үнэлээгүй байна.

Дунд хугацааны бодлогын уялдаа.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7¹-д аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг тодорхойлжээ. Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.2-т “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь дараах шаардлагыг хангасан байна:”, 6.7.2.а-д “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээс тухайн аймаг, нийслэл, хотод хамаарахыг өөрийн онцлогт нийцүүлэн тодорхойлсон байх;”, 6.7.2.б-д “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцсон төсөл, арга хэмжээг тусгасан хөтөлбөрийг хавсаргах;”, 6.7.2.в-д “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүнд уялдуулан орон нутгийн аливаа онцлогийг харгалзан зорилго, зорилт, хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшинг орон нутгийн түвшинд шинээр тодорхойлж болно.” гэж заасан байна.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д нийцүүлэн Орхон аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/01 дугаар тогтоолын хавсралтаар “Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг баталсан байна.

¹ “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт суурилсан орон нутгийн онцлогийг тусгасан дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг;

Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.3.3², 3.3.4³ дахь заалтуудыг тусгаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр бусад зорилтуудыг аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд бүрэн тусгасан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10⁴-д Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулахаар заасан байна.

Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтууд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудтай нийцсэн байна.Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, тусалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэргэжлийн сургалтад хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлнэ.
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр арга хэмжээний хүрээнд бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- Аймгийн хэмжээнд ажил олоход хүндрэлтэй иргэдийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, ажил хайгчийг тохирох ажлын байранд зуучилж, ажлын байр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжин ажиллана.
- Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

Богино хугацааны бодлогын уялдаа.

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлүүдийг 2016-2020 оны хооронд жил бүр баталсан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг 2020 оны 05 сард шинэчлэгдэн батлагдсаны дагуу аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2021 оны үндсэн чиглэлийг баталсан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1⁵-д аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэсэн байна гэж заасан байна.

² малчид, тариаланчдыг бизнесийн тогтвортой орлогын эх үүсвэртэй болгоно.

³ аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ.

⁴ "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг;

⁵ Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2016, 2017, 2018, 2019 онуудын үндсэн чиглэлд тусгасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээ нь Засаг даргын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилттой нийцсэн байна.

Мөн 2020, 2021 онуудын үндсэн чиглэлд тусгасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээ нь Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн байна.

Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг бодитой үнэлж, дүгнээгүй байна.

1.1.2 Орхон аймгийн иргэд, ААН-үүдийг зах зээлд эрэлттэй болон илүүдэлтэй мэргэжлийн талаарх мэдээллээр бүрэн хангаж чадаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлд Төрөөс хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжих талаар авах арга хэмжээний талаар заасан байдаг. Мөн Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын 2.1-д “Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын зорилго нь хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшинг бууруулахад чиглэнэ.” гэж заажээ.

ХЭҮЗ-ийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын хоёрдугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.2.6-д “*орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон үр дүнгийн судалгааг тодорхой давтамжтайгаар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагатай хамтран хийж, хэрэглэгчид, үйлчлүүлэгчдийг зах зээлд эрэлттэй болон илүүдэлтэй мэргэжлийн талаарх мэдээллээр хангах*” гэж заасан байдаг.

Орхон аймгийн Засаг даргын 2019 оны 02 сарын 01-ний өдрийн “Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа зохион байгуулах тухай” А/68 дугаар захирамжаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үр дүнгийн тоон болон чанарын судалгааг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг томилсон байна.

Тухайн судалгааг хийхэд Европын холбооны техник, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих-1 төсөл, Орхон аймгийн ЗДТГ, Хүнс хөдөө аж ахуйн газар, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Статистикийн хэлтэс, орон нутгийн их дээд сургууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд, Хангайн бүсийн арга зүйн төв хамтран зохион байгуулсан байна.

Судалгаанд 140 ажил олгогч, 240 ажилгүй иргэд, 800 ажил эрхэлж буй залуучууд, 80 малчин, МСҮТ-ийн суралцагчид, Ерөнхий боловсролын төгсөх ангийн сурагчид хамрагдсан байна.

Орхон аймгийн хөдөлмөрийн зах зээл дээрх ажиллах хүчний эрэлтийг ажил олгогчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн томоохон бүтээн байгуулалт, төсөвт байгууллагуудаас 2019-2021 онуудад

тэтгэвэрт гарах ажиллагсдын судалгаа, шинээр шаардлагатай орон тоо гэсэн эх үүсвэрүүдээр судалсан байна.

Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийг судлах зорилгоор Төрийн болон Төрийн бус өмчийн 3 их, дээд сургуулийн болон МСҮТ-ийн 240 суралцагч, мэргэжил сонголтын талаар ЕБС-ийн 200 сурагчдаас судалгаа авсан байна.

Тухайн судалгаанд Орхон аймагт эрэлттэй байгаа болон илүүдэлтэй байгаа мэргэжлийн талаарх мэдээллийг тодорхой дурдаагүй, хэрэглэгчдийг мэдээллээр бүрэн хангаж чадаагүй байна.

1.1.3 Орон нутагт бодлогын баримт бичгийг боловсруулахад бүх талуудын оролцоог хангасан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1⁶-д аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын баримт бичгийн төслийг хэвлэн нийтлэх талаар заасан байна. Тухайн баримт бичгийг боловсруулахад нутгийн захиргааны байгууллага хэлэлцүүлэг зохион байгуулах ба 19.2⁷-т заасан талуудыг хэлэлцүүлэгт хамруулахаар тусгасан байна.

Орхон аймаг, Эрдэнэт хотын “Ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025” бодлогын баримт бичгийг 2019 онд боловсруулсан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1⁸-д хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа бүх талын оролцоог хангасан байх зарчмыг баримтлахаар заасан бөгөөд 5 дугаар зүйлийн 5.2.13-д “бүх талын оролцоог хангасан байх зарчим гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэд, сонирхлын бүлгийн оролцоог ханган боловсруулсан байхыг” гэж тусгажээ.

Орхон аймаг дээрх хууль хэрэгжиж эхэлснээр дараах дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдийг боловсруулж, баталсан байна. Үүнд:

- Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,
- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- Орхон аймаг, Эрдэнэт хотын 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө.

⁶Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын баримт бичгийн төслийг хэвлэн нийтлэх, олон нийтэд танилцуулах, мэдээлэх, хэлэлцүүлэх, санал авах үйл ажиллагааг холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага зохион байгуулна.

⁷19.2.Энэ хуулийн 19.1-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага дараах хэлбэрээр хэлэлцүүлэг зохион байгуулж болно:

19.2.1.хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд;

19.2.2.эрдэмтэн судлаач, шинжээч зэрэг мэргэжлээр хүрээнд;

19.2.3.тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд;

19.2.4.төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд.

19.3.Холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага энэ хуулийн 19.2-т заасан хэлэлцүүлгийн үр дүнд гарсан саналыг хөгжлийн бодлогын баримт бичигт тусган боловсруулж, төслийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлнэ.

⁸Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлана.

Дээрх баримт бичгүүдийг боловсруулахад талуудын оролцоог бүрэн хангаж ажилласан байна.

1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

1.2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүгийн тооцоолол хийгдээгүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна.” гэж заасны дагуу аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд төсөв, санхүүгийн тооцоолол байгаа эсэхийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг тусгаагүй байна.
- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийт хөрөнгийн хэмжээ, төсвийг тусгасан байна.
- Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлүүдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлыг байрыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгагдсан арга хэмжээнүүдэд шаардагдах санхүүгийн эх үүсвэр, төсвийг тусгасан байна.

Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлээс бусад дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд төсөв, эх үүсвэрийг тусгасан байгаа хэдий ч санхүүгийн тооцоолол хийгдээгүй байна.

1.2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

Бодлогын баримт бичгүүдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн 2016-2021 онуудад батлагдсан дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгагдсан арга хэмжээнүүдийн эх үүсвэрийг бүрэн төлөвлөсөн байна.

1.2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг хуваарилсан байна.

Орхон аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.5.3-д “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” /НЭГ ӨРХ-НЭГ АЖЛЫН БАЙР/ хөтөлбөр хэрэгжүүлж иргэдийг ажилтай, орлоготой болгох зорилт дэвшүүлсэн байна.

- ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны 02 дугаар тогтоолоор баталсан төсөвт 100.0 сая төгрөг батлагдсан. Батлагдсан төсвийн хүрээнд 2017 онд Орхон

аймгийн Засаг даргын 2017 оны А/506, А/644 дүгээр захирамжаар 100.0 сая төгрөг батлуулан зарцуулсан байна.

- ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ны 09/04 дүгээр тогтоолоор баталсан төсөвт 100.0 сая төгрөг батлагдсан. Батлагдсан төсвийн хүрээнд 2018 онд Орхон аймгийн Засаг даргын 2018 оны А/365 дугаар захирамжаар 100.0 сая төгрөг батлуулан зарцуулсан.
- ИТХ-ын 2018 оны 11 дугаар сарын 30-ны 12/04 дүгээр тогтоолоор баталсан төсөвт 200.0 сая төгрөг батлагдсан. Батлагдсан төсвийн хүрээнд 2019 онд Орхон аймгийн Засаг даргын 2019 оны А/137 дугаар захирамжаар 200.0 сая төгрөг батлуулан зарцуулсан.
- ИТХ-ын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны 15/03 дугаар тогтоолоор баталсан төсөвт 278.0 сая төгрөг батлагдсан. Батлагдсан төсвийн хүрээнд 2020 онд Орхон аймгийн Засаг даргын 2020 оны А/12 дугаар захирамжаар 278.0 сая төгрөг батлуулан зарцуулсан.

Батлагдсан төсвийн хүрээнд 2017-2020 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ аймгийн ХХҮГ хэрэгжилтийг ханган хэрэгжүүлж ажилласан. Хөтөлбөрийн үр дүнд аймгийн хэмжээнд нийт 2880 өрхийн 3994 иргэний 662 өрх хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд, 256 өрх зорилтот өрх хөтөлбөрт, эргэн төлөгдөх нөхцөлтэй итгэлийн зээлд 133 иргэн, байнгын ажлын байранд 1219 иргэн, 1033 иргэн түр ажлын байранд зуучлагдсан байна.

ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны 02/05 дугаар тогтоолоор баталсан 2021 оны төсөвт 270.0 сая төгрөг батлагдсан.

Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дууссан тул аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 09-ны 09 дүгээр тогтоолоор “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүд хайртай хөтөлбөр”-ийг дахин баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааг Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк хариуцан, Засаг даргын захирамжаар батлагдсан 270.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй итгэлийн зээлд зарцуулсан байна.

1.3 Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох үйл ажиллагаа хоорондоо уялдаагүй байна.

1.3.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө уялддаг ч мэдээлэл солилцох үйл ажиллагаа хангалтгүй байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга нь аймгийн Засаг дарга болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтай үр дүнгийн гэрээ байгуулан ажилладаг байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн хэлтэс нь аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны тухайн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөгөөгөө боловсруулсан байна.

Хөдөлмөр халамжийн, үйлчилгээний газар бусад төрийн байгууллагуудын хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан төлөвлөгөөгөө боловсруулж байгаа боловч гүйцэтгэх өдөр тутмын ажилд төрийн байгууллагуудын уялдаагүй байдал ажиглагддаг байна. Тухайлбал:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 31.2.1-т “ажил олгогч нь нийт болон сул чөлөөтэй ажлын байр, шинээр бий болсон болон байхгүй болсон ажлын байрны

талаарх мэдээллийг энэ хуулийн 20.7-д заасан маягтын дагуу тогтоосон хугацаанд, ажиллагчдынхаа ур чадварыг хөгжүүлэх сургалтын хэрэгцээг тухай бүр аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад ирүүлэх” гэж заасны дагуу аж ахуйн нэгж байгууллагад ажлын байрны судалгаа ирүүлэх тухай албан бичиг хүргүүлдэг боловч аж ахуйн нэгж байгууллага бүр төдийлөн судалгааг хугацаанд нь ирүүлдэггүй байна.

Үйл ажиллагаа явуулж буй байгууллагын судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын хэлбэр	2016	2017	2018	2019	2020	2021
1	Хувьцаат компани	6	6	4	4	5	5
2	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	1,586	1,703	1,710	1,781	1,761	1,470
3	Бүх гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	21	21	18	19	18	14
4	Зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	69	70	51	54	52	42
5	Хоршоо	24	26	20	23	20	16
6	Төрийн өмчит үйлдвэрийн газар	1	1	1	1	1	1
7	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	6	7	6	6	6	6
8	Төсөвт байгууллага	96	97	100	101	102	104
9	Төрийн бус байгууллага	311	373	400	428	360	242
10	Бусад	3	4	12	15	14	11
	Нийт дүн	2,123	2,308	2,322	2,432	2,339	1,911

Статистикийн байгууллагаас ирүүлсэн судалгаагаар бүртгэлттэй байгаа аж ахуйн нэгж байгууллагаас үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн судалгааг гаргахад 2016-2020 онуудад тогтмол 2123-2432-т хэлбэлзэж байсан бол 2021 онд 1911 болж буурсан бөгөөд эдгээр байгууллагаас ажил эрхлэлтийн судалгааг 2016 онд 423 буюу нийт байгууллагын 20.0%, 2017 онд 406 буюу 17.6%, 2018 онд 231 буюу 9.9%, 2019 онд 27.4%, 2020 онд 543 буюу 23.2%, 2021 онд 19% нь ажлын байрны мэдээллийг ирүүлж буй нь хангалтгүй, аймгийн нэгдсэн мэдээлэл дутуу, бодитой бус илэрхийлэгдэж байна.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл олгохдоо сум хөгжүүлэх сан болон орон нутгийн “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ-аас гарааны бизнес дэмжих зээлүүдээс нэр давхардаж буй эсэхийг хянахаар зээл олгохын өмнө тус байгууллагад хүсэлт явуулж ирсэн мэдээллийг тулгадаг байсан бол сүүлийн нэг жилд хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг өгөх боломжгүй гэдэг тайлбарыг ирүүлдэг болсон нь зээлийн давхардал бий болох эрсдэлийг нэмэгдүүлж байна.
- Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2-д “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна” гэж заасны дагуу Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас татварын байгууллага болон нийгмийн даатгалын байгууллагад хүсэлт хүргүүлж 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгжийн судалгааг ирүүлэх хүсэлт явуулдаг ч Татварын ерөнхий хуулийн 13.2-дах заалт болон нууцын мэдээлэл хүргүүлэх боломжгүй гэсэн тайлбарыг ирүүлдэг байна. Гэтэл Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20.6-д “хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь улсын бүртгэл, статистик, татвар, нийгмийн даатгал, халамжийн асуудал эрхэлсэн холбогдох байгууллагатай тайлан, мэдээ,

мэдээлэл, холбогдох баримт бичгийг харилцан үнэ төлбөргүй солилцоно” гэсэн заалт хэрэгждэггүй байна.

1.3.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэг өрх-нэг ажлын байр хөтөлбөрийг хэрэгжүүлсэн боловч итгэлийн зээлийн үр дүнд хэдэн ажлын байр нэмэгдсэн нь тодорхойгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрмийн 2.1.4-т хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлагдсан хөтөлбөрүүд болон орон нутгийн онцлогтой хөтөлбөр төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг удирдан зохицуулах, биелэлтэд нь хяналт тавих гэж заасан.

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөс 2017-2020 онд хэрэгжүүлэхээр Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай дэд хөтөлбөрийн хүрээнд Нэг өрх-нэг ажлын байр хөтөлбөрийн аймгийн ИТХ-ын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 5/02 дугаар тогтоолоор батлуулсан.

“Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” /Нэг өрх-нэг ажлын байр/ дэд хөтөлбөрийг боловсруулах үндэслэл нь Орхон аймгийн 101.8 мянган хүн амын 64.5 хувь хөдөлмөрийн насных бөгөөд үүний 50.4 хувь нь хөдөлмөр эрхэлж, 22000 гаруй иргэн ажилгүй, ажилгүй иргэдийг судлахад өрхийн гишүүд нь огт ажил эрхэлдэггүй 1147 өрхийн 2314 иргэн байгаа нь гол нөлөөлсөн байна.

Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай дэд хөтөлбөрийн хүрээнд Нэг өрх-нэг ажлын байр хөтөлбөрийн зорилго нь өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх чадвартай иргэнийг тодорхойлж, тэдгээр өрх, өрхийн гишүүдийн эрэлт, хэрэгцээ, санаачилга боломжид тулгуурлан хөдөлмөрт бэлтгэх, ажилд зуучлах, мэргэжлийн ур чадвар олгох, ажлын байр бий болгоход нь дэмжлэг үзүүлэх зэрэг үйлчилгээг багцлан хүргэх замаар сонгогдсон өрх, иргэнийг ажилтай орлоготой болгож, амьжиргааны түвшинг тасралтгүй дээшлүүлэхэд оршино.

Дээрх зорилгын хүрээнд 5 зорилт дэвшүүлж 2017-2018 онуудад ХХҮГ-ын дансаар дамжуулан 63 иргэнд 151,000.0 мянган төгрөгийн бизнесийн дэмжлэг олгох зээл, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг төсөл сонгон шалгаруулалтын зохион байгуулж “Шинжлэн ухаан технологийн парк” ОНӨААТҮГ-ын дансаар дамжуулан 2019 онд 80 иргэнд 160,000.0 мянган төгрөг, 2020 онд 100 иргэнд 200,000.0 мянган төгрөг, 2021 онд 38 иргэнд 190,000.0 мянган төгрөг, хуванцар хог боловсруулалтын 2 аж ахуйн нэгжид 104,000.0 мянган төгрөг, нийт 805,000.0 мянган төгрөгийг гарааны бизнес дэмжих зорилготой итгэлийн зээл олгосон байна.

Гарааны бизнесийн дэмжлэгийн зээл олгох ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар байгуулдаг бөгөөд ажлын хэсгийн даргаар Засаг даргын нийгмийн асуудал хариуцсан орлогч ажилладаг бол гишүүдэд аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалтын хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хууль эрх зүйн хэлтсээс тус бүр нэг мэргэжилтэн, Шинжлэх ухаан технологийн паркийн захирал эсвэл менежерийн аль нэг нь, Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга гэсэн бүрэлдэхүүнтэй төсөл сонгон шалгаруулж зээл олгодог байна.

ХХҮГ-аас олгосон зээлээс 8,213.5 мянган төгрөгийн зээл үлдэгдэлтэй байгаа бол тайлант онд төлөгдсөн зээлийн эргэн төлөлтийг орон нутагт буцаан төвлөрүүлдэг байна.

Харин “Шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ-аар дамжин олгогдож буй 2019 оны зээлээс 57,465.0 мянган төгрөг буюу нийт зээлийн 36%, 2020 оны зээлээс 133,008.0 мянга буюу нийт зээлийн 66.5% нь зээлийн эргэн төлөлт хийгдээгүй үлдэгдэлтэй байна.

“Шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ-т жил бүр олгосон зээлийн санхүүжилт 592,000.0 мянган төгрөгөөс 2021 оны санхүүжилт 270,000 мянган төгрөгийг орон нутагт буцаан олгох өглөгөөр бүртгэсэн бол бусад 322,000.0 мянган төгрөгийг орон нутагт буцаан төвлөрүүлэх өглөгөөр бүртгэж тайлагнаагүй байна.

Өмнөх онуудад гарааны бизнес дэмжих зорилготой иргэнд 2,000.0 мянган төгрөг олгодог байсан бол 2021 оноос 5,000.0 мянган төгрөгөөр олгодог болсон байна.

Орхон аймгийн ажилгүй иргэдийн тооцоо судалгаанд үндэслэн Нэг өрх-нэг ажлын байр хөтөлбөрийг хэрэгжүүлж гарааны бизнесийг дэмжих зээл олгож буй нь сайшаалтай боловч сүүлийн 3 жилд Шинжлэх ухаан технологийн паркаар дамжуулан олгож буй зээлд ХХҮГ болон аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөс хэрэгжүүлсэн хяналт огт байхгүй байгаа нь олгогдож буй зээл зориулалтын дагуу зарцуулагдаж, ажлын байр нэмэгдэж буй эсэхийг бодитой, оновчтой тодорхойлох боломжгүй байна.

1.3.3 Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь хууль, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2016-2021 онуудад 3 удаа шинэчлэн баталсан байна.Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/15 дугаар захирамж.
- Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/222 дугаар захирамж
- Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/22 дугаар захирамж.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн дарга нь Засаг даргын нийгмийн асуудал хариуцсан орлогч байгаа нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 2 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрмийн 3.1-д “зөвлөлийн дарга нь тухайн аймаг, нийслэл дүүргийн засаг дарга байх бөгөөд гурван талын төлөөлөгчдийн тоо адил бөгөөд дараах бүрэлдэхүүнтэй байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

“Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрмийн 3.1.1-д төрийг төлөөлж Засаг дарга болон аймаг, нийслэл, дүүргийн боловсрол болон нийгмийн хөгжил, төсөв санхүүгийн байгууллагаас гурван хүн гэж заасан байтал хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн байгууллагыг төлөөлж:

Дарга- Засаг даргын нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч;

Нарийн бичгийн дарга- Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга;

Гишүүд- Аймгийн засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд- Аймгийн ЗДТГ-ын хүн ам зүй, хөдөлмөр халамжийн үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг 4 хүний бүрэлдэхүүнтэй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь улиралд нэг удаа хуралдаж тэмдэглэлийг баталгаажуулж ажилладаг байна.

Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн хийсэн онцлог ажлаас дурдвал:

- **2017 онд** Орхон аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.5.3-д “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” Нэг өрх-нэг ажлын байр дэд хөтөлбөрийг санаачлан боловсруулж аймгийн ИТХ-ын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 5/02 дугаар тогтоолоор батлуулж ХХҮГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан 2017 онд 26 иргэнд 72,000.0 мянга, 2018 онд 26 иргэнд 50,000.0 мянга, зээлийн эргэн төлөлтөөс 11 иргэнд 29,000.0 мянга нийт 63 иргэнд 151,000.0 мянган төгрөгийн зээлийг 2 жилийн хугацаатай, хүүгүй олгожээ. 2021 оны байдлаар нийт олгосон зээлээс 142,786.5 мянган төгрөгийн эргэн төлөлт хийгдэж хугацаа дууссан 6 иргэний 8,213.5 мянган төгрөгийг Орхон аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандсан байна.
- **2018 онд** Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн 25-аас дээш ажилтантай төрийн болон хувийн 125 аж ахуй нэгж байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж байгаа эсэх судалгаа авч, ажиллуулаагүй байгууллагуудад төлбөр төлөх нэхэмжлэлийг хүргүүлэн, төлбөрийг төлүүлэх чиглэлээр мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчидтай хамтран ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрт нийт 49.6 сая төгрөгийг ХЭДС-д төвлөрүүлжээ.
- **2019 онд** “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, тоон болон чанарын судалгаа”-г аймгийн ЗДТГ, Европын холбооны “Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих -1 төсөл”-тэй хамтран хийж дээрх зардлаас 10,0 сая төгрөгийг зарцуулж, ажил олгогч 140, ажилгүй 240, хөдөлмөр эрхэлж буй 800, оюутан 240, хувиараа хөдөлмөр эрхлэгч 600, сурагч 200, малчин 80 буюу нийт 2300 иргэн хамрагдсан. Орхон аймагт өнгөрсөн оны байдлаар ажилгүйдлийн түвшин 23.5 хувь буюу улсын дунджаас 14.7 пунктээр өндөр байгаа нь ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн харьцаа алдагдсан, их, дээд сургууль төгсөгчид шууд ажилгүйчүүдийн эгнээнд ордог, шилжилт хөдөлгөөн их байгаатай холбоотой гэж тодорхойлсон. Мөн сүүлийн таван жилд Орхон аймгийн хүн ам жилд дунджаар 2.6 мянга, хөдөлмөрийн насны хүн ам 400-аар нэмэгдсэн нь ажилгүй иргэдийн тоог төдий хэмжээгээр нэмсэн байна. Нийт 105.8 мянган хүн амын 62.8 хувь хөдөлмөрийн насных бөгөөд үүний 62.6 хувь нь хөдөлмөр эрхэлж байна гэсэн судалгааг гаргажээ.
- **2020 онд** 2019-2020 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд орсон өөрчлөлтийн талаар танилцуулж тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, ХЭД сангийн жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн байдалд ХХҮГ-ын мэргэжилтнүүдтэй хамтарч хяналт тависан талаар танилцуулж үр дүнгийн талаар хэлэлцсэн.
- **2021 онд** ЦТҮААЭСХөтөлбөрийн үйлчилгээний чиглэлээс лангуу болон бөөний худалдаа эрхлэгчдээс гадна үсчин гоо сайхны үйлчилгээ эрхлэгчдийг хассан, ЗХЭДХ-ийн санхүүгийн дэмжлэгийн тэргүүлэх чиглэлийг “Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцсэн шинэ технологи, инноваци шингэсэн бренд бүтээгдэхүүн, үйлчилгээ”-г дэмжсэн байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/75 дугаар тушаалын дагуу ажлын оролцоо, хурлын ирцийг харгалзан улирал тутам олгох

урамшууллын хэмжээг 150.0 мянган төгрөгөөр тогтоосны дагуу Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн гишүүдэд улирал бүр урамшууллыг олгодог байна.

1.3.4 Хагас бүтэн жилээр дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хийгддэг боловч өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож, баримтжуулаагүй байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтэс нь тухайн жилийн үйл ажиллагааны тайлан болон биелэлтийг гаргаж захиргаа хяналтын хэлтэст хүргүүлж, хяналт шинжилгээ үнэлгээний ажилтан хяналт хэрэгжүүлж ХХҮГ-ын нэгтгэл тайланд нэгтгэгддэг байна.

Харин аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс ХХҮГ-ын даргын Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтэд жил бүр үнэлгээ өгч ажилладаг. Мөн Засаг даргын мөрийн хөтөлбөрт хяналт хэрэгжүүлдэг боловч жил бүрийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланд хяналт хэрэгжүүлдэггүй байна.

ХХҮГ-ын дотоод хяналтын тайлангаас үзэхэд:

2019 онд:

- Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд 3
- Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 6
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 3
- Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 1
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 5
- Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2 нийт 20 зөвлөмжийг Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст хүргүүлж ажилласан.

2021 онд:

- Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд хяналт хэрэгжүүлж зөвлөмжүүдийг хүргүүлж ажилласан.

Хяналт хэрэгжүүлсэн тайлангуудаас 2019, 2021 оны тайлангуудыг ирүүлсэн бол 2016 оны тайланг цаасаар бусад 2017, 2018 оны тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.

Жил бүр ХХҮГ-ын дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүд хяналт хэрэгжүүлж зөвлөмжийг хэлтсүүдэд хүргүүлж байгаа боловч өгсөн зөвлөмжийн хэдийнх нь хэрэгжилт бүрэн хангагдсан, биелэлт хангагдаагүй хэдэн зөвлөмж үлдсэн эсэх нь тодорхойгүй, зөвлөмжийн тоон мэдээллийг нэгтгэж гаргадаггүй байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байна уу?

Бүлэг 2

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хууль, журмын дагуу хэрэгжүүлдэг ч төсөл хөтөлбөрийн үр дүнд, иргэдийн амьдрал хэрхэн дээшилж, ажилгүйдэл буурсан эсэх нь тодорхойгүй байна.

2.1 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааг үр нөлөөтэй, хэмнэлттэй зохион байгуулсан байна.

2.1.1 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлөөс ирүүлсэн квотыг хангасан байна.

Жилд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээний квотыг Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих үндэсний зөвлөлөөс баталж ирүүлдэг байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг 2016-2021 оныг квотын тоо болон гүйцэтгэлийг харьцуулж үзвэл:

Он		Бүлгээр	Ганцаарчилсан	Нийт
2016	Төлөвлөгөө		1,334	1,334
	Гүйцэтгэл	1,222	112	1,334
2017	Төлөвлөгөө		1,100	1,100
	Гүйцэтгэл	825	63	888
2018	Төлөвлөгөө		1,924	1,924
	Гүйцэтгэл	1,070	854	1,924
2019	Төлөвлөгөө		2,170	2,170
	Гүйцэтгэл	1,520	650	2,170
2020	Төлөвлөгөө		2,170	2,170
	Гүйцэтгэл	1,530	640	2,170
2021	Төлөвлөгөө		2,023	2,023
	Гүйцэтгэл	1,383	640	2,023

Дээрх тоон үзүүлэлт нь дараа оны 1 дүгээр сарын 03-ны дотор LMIS программаас гаргадаг жилийн мэдээгээр гаргасан үзүүлэлт юм.

Харин ХХҮГ-ын жилийн эцсийн үйл ажиллагааны тайланд дараах байдалтай тусгагдсан байна.


- 2016 онд: “Монголын ажил мэргэжлийн мэргэшсэн зөвлөхүүдийн холбоо” ТББ-ыг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажилласан. Ганцаарчилсан хэлбэрээр 77 ажилгүй иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээлэл, бүлгээр нийт 335 иргэнд АМЧБОЗӨ үйлчилгээг хүргэсэн. Үүнд: Хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 141 иргэн, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2015, 2016 онд хамрагдаж бүлгийн зохион байгуулалтайгаар үйл

ажиллагаа явуулж байгаа 40 иргэн, Даваат багийн 19, Говил багийн 29, Шанд багийн 25 ажилгүй иргэн, Цагдаагийн газрын захиргааны хяналтад байгаа 32 иргэн, ШШГБ-д хорих ял эдэлж байгаа 49 иргэнд тус тус АМЧБОЗӨ үйлчилгээг хүргэсэн. ЕБС-ийн 420, ажилгүй болон ажил олоход хүндрэлтэй 409 иргэнд ганцаарчилсан болон бүлгээр АМЧБОЗӨ үйлчилгээг хүргэсэн байна.

- 2017 онд Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ ганцаарчилсан хэлбэрээр нийт 555 иргэнд хөдөлмөр эрхлэлт, ажилд зуучлах үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласны 386 нь эмэгтэйчүүд байжээ. Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний Ерөнхий Газраас эрх авсан Орхон МСҮТ болон “Мөнх-Оюуны холбоос” сургалтын байгууллагуудтай хамтран ЕБС, МСҮТ-ийн суралцагсад, цэргээс халагдсан, ажил хайгч, хорих ангид хүмүүжиж буй, хөгжлийн бэрхшээлтэй нийт 825 иргэнийг хамруулж ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг явуулсан.
- 2018 онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх бүлгийн сургалт зохион байгуулах эрх бүхий сургалтын байгууллага “Вэст Метод” ХХК-тай хамтран бүлгийн хэлбэрээр Ажил хайгч –118, Хөгжлийн бэрхшээлтэй-74, Хорих ангид хүмүүжиж суллагдах- 70, Их дээд болон МСҮТ-ийн төгсөх ангийн оюутнууд – 80, Эмзэг эрсдэлтэй бүлгийн – 728 иргэдэд сургалтыг зохион байгууллаа. Нийт 1070 иргэн сургалтад хамрагдаж сургалтын зардалд 6.4 сая төгрөг зарцуулжээ.
- 2019 онд Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ ганцаарчилсан хэлбэрээр нийт 650 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч 7.8 сая төгрөг зарцуулсан. Үүний 451 нь эмэгтэйчүүд байсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг нийт 60 удаагийн сургалт зохион байгуулж 1520 иргэн хамрагдаж 9.1 сая төгрөг зарцуулсан.
- 2020 онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх бүлгийн сургалтыг ХХҮЕГ-аас эрх авсан сургалтын байгууллагын жагсаалтад орсон “Эм Эс Девелопмент консалинг” ХХК-тай хамтран бүлгийн сургалтыг зохион байгуулж, ЕБС-ийн 8-9-р ангийн 820 сурагчид, ажил хайгч иргэн 323, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 35, эмзэг эрсдэлтэй бүлгийн 139, мэргэжлийн боловсролын байгууллагын суралцагч 143, хорих ангид хүмүүжигч болон суллагдсан иргэд 60, нийт 1520 иргэд хамрагдаж мэргэжил сонголт болон ажил хөдөлмөрт хэрхэн бэлтгэх чиглэлээр мэдлэг олгож, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ ганцаарчилсан хэлбэрээр нийт 640 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсний 298 нь эмэгтэйчүүд байна.
- 2021 онд: ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ ганцаарчилсан хэлбэрээр нийт 120 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллажээ. Үүний 72 нь эмэгтэйчүүд байсан.

LMIS программаас ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний тоон үзүүлэлт, жилийн үйл ажиллагааны тайлангийн тоон үзүүлэлтүүд зөрүүтэй илэрхийлэгдсэн нь LMIS программ нь бүтэн жилийн тоон үзүүлэлт бол үйл ажиллагааны тайлангийн тоон үзүүлэлт нь 11 дүгээр сарын 25-ны өдрөөр тасалбар болгосон тоон үзүүлэлт байдаг байна.

Ажилд зуучлах үйлчилгээний доод квотыг мөн адил Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлөөс жил бүр баталж, ажилд зуучлах үйлчилгээг 2016-2017 онуудад 1,000, 2018-2019 онуудад 1,100, 2020-2021 онуудад 1,000 хүнийг хамруулахаар шийдвэр ирүүлсэн.



Харин гүйцэтгэлээр 2016 онд 1,954, 2017 онд 1,170, 2018 онд 1,256, 2019 онд 1,368, 2020 онд 1,000, 2021 онд 1,032 хүнийг ажилд зуучилсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлөөс баталж өгсөн ажилд зуучлах квотыг 2016 онд 954, 2017 онд 170, 2018 онд 156, 2019 онд 268-иар төлөвлөгөөг давуулан биелүүлсэн бол 2020-2021 онуудад Ковид цар тахалтай холбоотой төлөвлөгөөг таслаагүй байна.

Ажилд зуучлах үйл ажиллагаанд LMIS программд ажил хайгчаар бүртгэл үүсэж, ажилд зуучилснаар тоон үзүүлэлт гардаг бол ажил хайгчаар бүртгэгдсэн иргэн зуучлалаар бус өөрөө ажлаа олсон бол тус программд бүртгэх сонголт байхгүй ажилд зуучилснаар бүртгэл хаагддаг учир дутагдалтай байна.

Харин ажилд зуучлуулсан тоо, өөрөө ажил олсон тоо гэж 2 салдаг байх нь мэдээлэл үнэн зөв илэрхийлэгдэхээр байна.

2.1.2 ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтэс нь хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системийг байнга ашиглаж, мэдээ тайлангаа бэлтгэдэг ч программын сайжруулалт хийгдээгүй байна.

ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагаандаа ашигладаг LMIS программ буюу хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем нь ажил олгогч, ажил хайгч, албан бус хөдөлмөр эрхлэгч, ажлын байрны талаар мэдээллийг багийн хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн болон хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтнүүд ажил олгогчоос ирүүлсэн судалгаа, багаар үйлчлүүлсэн иргэдийн мэдээлэлд тулгуурлан оруулдаг байна.

LMIS программ дараах сул талтай байна.

- 2012-2013 онд анхан үүссэн тэрнээс программын шинэчлэл хийгдээгүй.
- Программд нэвтэрч ороход ачаалал ихтэй, 4-5 удаа оролдож нэвтэрдэг, удаан уншдаг, гацдаг.
- Ажилд зуучлалын тоо бодитой гардаггүй. Учир нь ажил хайгчаар бүртгүүлсэн иргэн өөрөө ажилд орсон тохиолдолд программд зуучилснаар л хаагддаг нь зуучилсан иргэдийн тоо бодитой гарах боломжгүйгээр хийгдсэн.

- Хөдөлмөрийн зах зээлийн мэдээг LMIS программаас татахад нийт бүртгэлтэй ажил хайгч иргэдээс хэдэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгүүлсэн байгаа мэдээг тусдаа салгаж харах боломжгүй. Нэг бүрчлэн иргэний регистрийн мэдээллээр оруулж хайх шаардлага үүсдэг.
- Мэдээллээ шинэчилж шивхэд хадгалагддаггүй. Дахин оруулах шаардлага үүсдэг.
- Бүртгэлтэй ажил хайгчийг өмнө нь ажил эрхэлж байсан байдлыг харах боломжгүй болсон. /Урамшуулал олгоход 6-сараас дээш бүртгэлтэй байсан эсэхийг харж тухайн аж ахуйн нэгжид урамшуулал олгоход заавал НД-аас тодорхойлолт шаардах хүндрэлтэй болсон/
- Нийгмийн даатгал, Улсын бүртгэл, татварын хэлтсийн цахим мэдээлэлтэй холбогдоогүй. Мэдээлэл солилцох хүсэлт явуулахад нууцын зэрэглэлтэй гээд мэдээлэл ирүүлдэггүй болсон.
- Шинээр ажил хайгчаар бүртгүүлсэн иргэдийн мэдээллийг шинээр оруулахад регистрийн дугаарыг хийхэд бусад шаардлагатай мэдээллийг автоматаар татаж гаргадаггүй, нэг бүрчлэн иргэнийн мэдээллийг шивж оруулж, цаг хугацаа ихээр шаарддаг.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн мэдээллийг 2020 оноос бүртгэж болохгүй болсон нь зээл давхардуулан олгох, мэдээллийн бааз үүсэх боломжийг хаагдуулсан.

Иймд программын сул талуудыг арилгаж, программын шинэчлэлийг хийж, хөдөлмөрийн хэлтсийн ажиллах хүчний ажлыг хөнгөвчлөх шаардлагатай байна.

Мөн Хөдөлмөрийн хэлтсийн LMIS программ нь Хөдөлмөрийг дэмжих тухай хуулийн 31.2.1-т “ажил олгогч нь нийт болон сул чөлөөтэй ажлын байр, шинээр бий болсон болон байхгүй болсон ажлын байрны талаарх мэдээллийг энэ хуулийн 20.7-д заасан маягтын дагуу тогтоосон хугацаанд, ажиллагчдынхаа ур чадварыг хөгжүүлэх сургалтын хэрэгцээг тухай бүр аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад ирүүлэх” заасны дагуу аж ахуйн нэгжээс ирүүлсэн мэдээлэлд тулгуурладаг нь хөдөлмөрийн зах зээлийн тоон судалгаа болон статистик үзүүлэлт бодитой үнэн зөв гарахгүй байхад нөлөө үзүүлж байна.

2.1.3 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд баталсан хөрөнгийг хэмнэлттэй зарцуулжээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.2-т “Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ”. Үүнд:

- 6.2.1. ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
- 6.2.2. ажилд зуучлах;
- 6.2.3. ажилгүйдлийн тэтгэмж олгох;
- 6.2.4. нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах;
- 6.2.5. бусад үйлчилгээ.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан төсөв хөрөнгийг төлөвлөгөө гүйцэтгэлтэй харьцуулахад дараах байдалтай байна.

№	Хөтөлбөр нэр	2016 он		2017 он		2018 он		2019 он		2020 он		2021 он	
		Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц
1	Ажилд зуучлах үйлчилгээ	5,991	5,991	11,550	10,153	11,020	10,613	11,760	11,760	3,472	2,296	6,160	6,160
2	АМЧБОЗӨҮ	13,750	13,750	13,188	6,315	24,096	14,100	26,802	14,628	11,000	11,000	15,156	14,495
3	Бусад арга хэмжээ	15,100	15,100	5,000	3,573	0	0	76,000	69,838	16,700	11,950	19,003	11,581
	Нийт	34,841	34,841	29,738	20,041	35,116	24,713	114,562	96,226	31,172	25,246	40,319	32,236

Дээрх хүснэгтээс үзэхэд 2017 онд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулах төсвийг 29,738.0 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 20,041.0 мянган төгрөг зарцуулж 9,697.0 мянган төгрөг хэмнэсэн, 2018 онд 35,116.0 мянган төгрөг баталж 24,713.0 мянган төгрөг зарцуулж 10,403.0 мянган төгрөг хэмнэсэн, 2019 онд 114,562.0 мянган төгрөг баталж 96,226.0 мянган төгрөг зарцуулж 18,336.0 мянган төгрөг хэмнэсэн, 2020 онд 31,172.0 мянган төгрөг зарцуулж 25,246.0 мянган төгрөг зарцуулж 5,926.0 мянган төгрөг хэмнэсэн, 2021 онд 40,319.0 мянган төгрөг баталж 32,236.0 мянган төгрөг зарцуулж 8,083.0 мянган төгрөг тус тус хэмнэсэн үзүүлэлттэй байна.

Ажилд зуучлах үйлчилгээ:

- 2016 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлөөс 1,000 иргэнийг ажилд зуучлахад 5,991.0 мянган төгрөг /нэг хүнд ногдох зардал 5,991 төгрөг/ баталсан бол гүйцэтгэлээр 1,954 иргэнийг ажилд зуучлахад 5,991.0 мянган төгрөгийг /нэг хүнд ногдох зардал 3,066 төгрөг/ зарцуулсан.
- 2017 онд мөн 1,000 иргэнийг ажилд зуучлах хөтөлбөрт 11,550.0 мянган төгрөг /нэг хүнд ногдох зардал 11,550 төгрөг/ баталсан бол 1,170 иргэнийг 10,153.0 мянган төгрөгийг /нэг хүнд ногдох зардал 8,677 төгрөг/ зарцуулсан.
- 2018 онд 1,100 иргэнийг ажилд зуучлах квотод 11,020 мянган төгрөг баталж /нэг хүнд ногдох зардал 10,018 төгрөг/ гүйцэтгэлээр 1,256 иргэнийг 10,613.0 мянган төгрөг зарцуулж /нэг иргэнд ногдох зардал 8,450 төгрөг/ зарцуулсан.
- 2019 онд мөн 1,100 иргэнийг ажилд зуучлах зардалд 11,760.0 мянган төгрөг /нэг иргэнд ногдох зардал 10,691 төгрөг/ баталж, гүйцэтгэлээр 1,000 иргэнд 11,760.0 мянган төгрөг зарцуулжээ.
- 2020 онд 1,000 иргэн ажилд зуучлахад 3,472.0 мянган төгрөг /нэг иргэнд ногдох зардал 3,472 төгрөг/ баталж, гүйцэтгэлээр 1,000 иргэнийг ажилд зуучилж 2,296.0 мянган төгрөг /нэг иргэнд ногдох зардал 2,296 төгрөг/ зарцуулсан.
- 2021 онд 1,000 иргэнийг ажилд зуучлахад 6,160.0 мянган төгрөг /нэг иргэнд ногдох зардал 6,160 төгрөг/ баталж гүйцэтгэлээр 1,032 иргэнийг ажилд зуучилж 6,160.0 мянган төгрөг /нэг иргэнд ногдох зардал 5,969 төгрөг/ -ийг тус тус зарцуулсан.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ:

- 2016 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлөөс ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээнд 1334 иргэн хамруулахад 13,750.0 мянган төгрөгийн /нэг иргэнд ногдох зардал 10,307 төгрөг/ төсөв баталснаас гүйцэтгэлээр 1,334 иргэнийг хамруулж 13,750.0 мянган төгрөг зарцуулсан.

- 2017 онд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээнд 1,100 иргэнийг хамруулахад 13,188.0 мянган төгрөг /нэг хүнд ногдох зардал 11,989 төгрөг/ баталж гүйцэтгэлээр 888 иргэнийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулж 6,315.0 мянган төгрөг /нэг хүнд ногдох зардал 7,112 төгрөг/ зарцуулж 6,873.0 мянган төгрөгийг хэмнэсэн байна.
- 2018 онд 1,924 иргэнийг ажлын чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээнд хамруулахад 24,096.0 мянган төгрөгийг /нэг хүнд ногдох зардал 12,524 төгрөг/ баталснаас гүйцэтгэлээр 1,924 иргэнийг хамруулж 14,100.0 мянган төгрөгийг /нэг хүнд ногдох зардал 7,328 төгрөг/ зарцуулж, 9,996.0 мянган төгрөг хэмнэсэн.
- 2019 онд 2,170 иргэнийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ өгөхөд 26,802.0 мянган төгрөг /нэг иргэнд ногдох зардал 12,351 төгрөг/ баталж, гүйцэтгэлээр 2,170 иргэнийг 14,628 төгрөг зарцуулж / нэг иргэнд 6,741 төгрөг/ 12,174.0 мянган төгрөгийг хэмнэсэн.
- 2020 онд 2,170 иргэнийг хамруулахад 16,700.0 мянган төгрөг баталж /нэг хүнд ногдох зардал 7,696 төгрөг/, гүйцэтгэлээр 2,170 иргэнийг 11,950.0 мянган төгрөгийг /нэг хүнд ногдох зардал 5,507 төгрөг/ зарцуулж 4,750.0 мянган төгрөг хэмнэсэн байна.
- 2021 онд 2,023 иргэнийг хамруулахад 15,156.0 мянган төгрөг /нэг хүнд ногдох зардал 7,492 төгрөг/ баталснаас гүйцэтгэлээр 2,023 иргэнийг хамруулахад 11,581.0 мянган төгрөг / нэг хүнд ногдох зардал 5,725 төгрөг/ зарцуулж 7,422.0 мянган төгрөг хэмнэсэн.

2.2 Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад, дотоодын зээл, тусламж, ОУБ-уудын санхүүжилттэй төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, чиглэлээр гадаад болон дотоодын зээл, тусламж, олон улсын байгууллагуудын санхүүжилттэй төсөл, хөтөлбөр Орхон аймагт хэрэгжээгүй байна.

2.2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлөөс эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлээгүй, хөдөлмөрийн зах зээлийн ажил хайгч, ажилд зуучлуулсан иргэд болон бизнесийн гарааны дэмжлэгийн 60 орчим хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.


Тухайн жилд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг ХЭДС-ийн төсөвтэй хамт хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталж ирүүлдэг.

ХХҮГ-ын газрын хөдөлмөрийн хэлтсийн LMIS программд бүртгэлтэй хөдөлмөрийн зах зээлийн сүүлийн 5 жилийн судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь дараах байдалтай байна. Бүртгэлтэй ажилгүй иргэд хувьд:

№	Бүртгэлтэй ажилгүй иргэн	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
1	Нийт тоо	1,229	1,399	1,226	1,361	1,032
2	Үүнээс: эмэгтэй	705	790	696	746	628
3	Үүнээс: эрэгтэй	524	609	530	615	404

Бүртгэлтэй ажил хайгчдын бүртгэл 2017 онд 1,229 хүн бүртгүүлсний 705 нь эмэгтэй буюу 57.4%, 2018 онд 1,399 ажил хайгчаас 790 нь эмэгтэй буюу 56.5%, 2019 онд 1,226 ажил

хайгчаас 696 нь эмэгтэй буюу 56.8%, 2020 онд 1,361 ажил хайгчийн 746 нь эмэгтэй буюу 55.4%, 2021 онд 1,032 ажил хайгчийн 628 нь эмэгтэй буюу 60.8%-ийг тус тус эзэлж байна. Графикаар харвал дараах байдалтай байна.



Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2017 онд 1,229 байсан бол 2018 онд 1,399 болж 170 нэмэгдсэн, 2020 онд 2017 харьцуулахад 132 нэмэгдэж 1,361, 2021 онд 830 нэмэгдэж 2,059 болсон нь бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо нэмэгдэх тусам эмэгтэйчүүдийн эзлэх тоо нэмэгдсээр байгааг харуулж байна.

Ажил хайгч иргэдийг насны ангиллаар задалж үзэхэд дараах байдалтай.

№	Он	15-24 нас		25-34 нас		35-44 нас		45-60 нас	
		эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
1	2017 он	87	96	189	324	116	167	132	118
2	2018 он	109	121	194	295	150	219	156	155
3	2019 он	85	121	188	242	145	204	112	129
4	2020 он	94	116	178	259	198	215	145	156
5	2021 он	85	112	124	227	107	182	88	107
6	Нийт	460	566	873	1,347	716	987	633	665

15-24 насны эмэгтэй ажил хайгчийн тоо 2017 онд 96 байсан бол 2021 онд 112 болж нэмэгдсэн, 25-34 насны эмэгтэй ажил хайгч 2017 онд 324 байсан бол 2021 онд 227 болж 97 буурах хандлагатай байхад 35-44 насны эмэгтэй ажил хайгч 2017 онд 182 болж нэмэгдсэн, 45-60 насны ажил хайгч эмэгтэй 2017 онд 118 байсан бол 2021 он 107 болж буурсан байна.

Ажил зуучилсан иргэдийн хувьд:

№	Ажилд зуучилсан иргэн	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
1	Нийт тоо	1,170	1,256	1,368	1,081	1,032
2	Үүнээс: эмэгтэй	662	769	796	913	628
3	Үүнээс: эрэгтэй	508	487	572	168	404

ХХҮГ-ын LMIS программд ажил хайгчаар бүртгүүлсэн иргэдээс 2017 онд 1,170 иргэнийг ажилд зуучилсны 662 эмэгтэй ба 56.6%, 2018 онд 1,256 иргэнийг ажилд зуучилсны 769 эмэгтэй буюу 61.2%, 2019 онд 1,368 иргэнийг ажилд зуучилсны 796 58.2%, 2020 онд 1,081 иргэн ажилд зуучилсны 913 эмэгтэй буюу 84.5%, 2021 онд 1,032 ажилд зуучилсны 628 эмэгтэй буюу 60.8%-ийг тус тус эзэлж байна.

Бүртгэлтэй ажил хайгчдын сүүлийн 5 судалгааны дунджаар 57 орчим хувийг эмэгтэйчүүд эзэлж байсан бол ажилд зуучилсан нийт иргэдийн 64 орчим хувийг эмэгтэйчүүд эзэлдэг байна.

Харин Эрдэнэтчүүд- эрдэнэтчүүддээ хайртай Нэг өрх-нэг ажлын байр хүрээнд олгосон барьцаагүй, хүүгүй зээлэнд ХХҮГ-аас 63 иргэнд 151.0 сая төгрөг, Шинжлэх ухаан технологийн паркаас 218 иргэнд 550.0 сая төгрөгийн зээлийг олгосон.

- ХХҮГ-аас олгосон зээлийн 63 иргэний 151.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн 38 эмэгтэйд 87.0 сая төгрөг буюу нийт зээлийн 60%-ийг эзэлж байна.
- Шинжлэх ухаан технологийн паркаас олгосон 218 иргэний 550.0 сая төгрөгийн зээлээс 135 эмэгтэйд 351.0 сая төгрөгийн зээл буюу нийт зээлийн 62% нь эмэгтэйчүүдэд олгогдсон байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон зээл 2016 оноос 2021 оны хооронд нийт 426 иргэнд 1,713,375.0 мянган төгрөгийн зээл олгосноос 238 эмэгтэйд 734,500.0 мянган төгрөг, нийт зээл олгосон иргэнээс 56%-ийг эмэгтэйчүүд эзэлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2016-2020 онуудад эмэгтэйчүүдэд чиглэсэн тусгайлсан хөтөлбөр арга хэмжээ баталж хэрэгжүүлээгүй байна.

Харин 2021 онд эмэгтэйчүүдийн дэмжих төсөлд 2,000.0 мянган төгрөг баталсныг хувиараа бизнес эрхэлдэг эмэгтэйчүүдэд 2 удаа зохион байгуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 1 дугаар тогтоолын 7-р хавсралтаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зорилго, зорилт, хамрах хүрээ, хэрэгжүүлэх зарчим, хэрэгжүүлэх арга хэмжээг баталж, төсөв зардалд 29,396.0 мянган төгрөг батлагджээ.

2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлсэн, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн дүнд иргэдийн амьдрал дээшилж байгаа нь тодорхойгүй, зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

2.3.1 ХЭДС-ийн орлогыг хуульд заасны дагуу бүрэн төвлөрүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 5 дугаар бүлгийн 22 дугаар зүйлд хөдөлмөр эрхлэлт дэмжих сангийн орлогыг нийт 9 төрлийн эх үүсвэрээс бүрдэхээр хуульчилсан байна. Хуулийн дагуу орсон орлогыг Хөдөлмөр эрхлэх төв сангийн дансанд төвлөрүүлэн шилжүүлдэг байна. 2016 оноос 2021 оны хооронд төв санд төвлөрүүлсэн орлогыг хүснэгтээр гарган үзүүлээ.

		/Мян.Төг/					
Д/д	Төвлөрүүлэлт	2016он	2017он	2018он	2019он	2020он	2021он
1	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	50,312.2	111,559.6	248,356.9	263,018.5	251,103.1	234,971.1
2	ХБИ-ийн ажиллаагүй төлбөрийн орлого	10,713.6	15,528.0	49,656.0	501,723.6	81,223.1	747,489.0
3	Бусад төвлөрүүлэлт	33,647.9	20,726.5	3,588.5	7,088.9	11,967.0	111,431.9
Нийт төвлөрүүлэлт		94,673.7	147,814.1	301,601.4	771,830.9	344,293.2	1,093,891.9

Орлогыг графикаар гарган үзүүлбэл



Дээрх хүснэгт болон графикаас харахад нийт орлогын төвлөрүүлэлт 2018, 2019, 2021 онууд өмнөх тухайн жилийн онуудаасаа 31-49 хувиар нэмэгдсэн үзүүлэлт харагдаж байна.

Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн орлого 2018 оноос тогтмол, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй төлбөрийн орлогын төвлөрүүлэлт он тус бүр өөр өөр дүнтэй буюу өсөж, буурсан байна. Энэ нь зарим аж ахуйн нэгж байгууллагаас 2 жилд нэг удаа төлүүлсэнтэй холбоотой. Бусад орлогын төвлөрүүлэлт ангилалд дээд газраар өгсөн санхүүжилтийн буцаалт, оны эцсийн дансны үлдэгдэл зэргийг хамруулсан болно.

Эдгээр орлогыг төвлөрүүлэхэд аль байгууллагын ямар дансанд хэрхэн яаж ямар хугацаанд төвлөрүүлэх талаар зохицуулагдаагүй байна.

2.3.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан боловч хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн дүнд иргэдийн амьдрал дээшилж байгаа нь тодорхойгүй, зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг тулган баталгаажуулалт хийлээ. Шалгалтын явцад нийтдээ 120 гаруй айл, ажлын байрыг хаягаар нь очиж үзсэн болно.

Орхон аймгийн хэмжээнд 2016-2021 оны хооронд ажлын байрыг дэмжих 225 хөтөлбөр хэрэгжүүлж 847.2 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжиж 75 хөтөлбөрт 271.0 сая төгрөг, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих 39 хөтөлбөрт 307.0 сая төгрөг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх 36 хөтөлбөрт 95.0 сая төгрөг, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 53 хөтөлбөрт 242.7 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүүгүй, 2.5-10.0 сая хүртэл хэмжээтэй зээл олгох замаар явуулдаг байна.

Одоогийн байдлаар нийт 5 хөтөлбөрт 1,762.9 сая төгрөгийн зээл олгогдсоноос 1,155.2 сая төгрөг эргэн төлөгдсөн, 462.4 сая төгрөгийн зээл хэвийн, 145.3 сая төгрөгийн зээл эргэлзээтэй байдалтай байна.

Багууд дээр хэлэлцүүлэг хийж дэмжигдсэн хөтөлбөрийг ХХҮГ-аас тусгайлан томилогдсон зөвлөл хэлэлцэн зээлийг олгодог байна.

Тухайн олгосон зээл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналтын комиссоос хяналт хэрэгжүүлж байна.

Энэ бүхний үр дүнд 198 хөтөлбөр амжилттай хэрэгжиж дууссан, 181 хөтөлбөр хэрэгжиж байгаа, хэрэгжилт удаашралтай байгаа 49 хөтөлбөр, 15 хөтөлбөрийн зээлийн асуудлаар шүүхэд шилжүүлсэн, 25 хөтөлбөрийг шүүхэд шилжүүлэхэд бэлтгэж байна.

	Төсөл хөтөлбөрийн нэрс	Хэрэгжүүлсэн он	Хөтөлбөрийн тоо	Хөтөлбөрийн хөрөнгийн хэмжээ	Хэрэгжиж дууссан	Хэрэгжиж байгаа /амжилттай/	Хэрэгжилт муу байгаа	/Хүснэгтээр/ Үүнээс	
								Шүүхэд шилжүүл	Цаашид асуудалт ай эргэн төлөлт
1	Ажлын байр дэмжих	2017 оноос	225	847.2	110	99	16	10	6
2	Залуучуудын ажлын байр дэмжих	2017 оноос	39	307.0	11	10	18	4	14
3	Ахмадын ажлын байр дэмжих	2017 оноос	36	95.0	20	15	1	-	-
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байр дэмжих	2017 оноос	75	271.0	21	42	12	-	5
5	Малчдын ажлын байр дэмжих	2016 оноос	53	242.7	36	15	2	1	-

Орхон аймгийн хэмжээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдээс оёдлын чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээ амжилттай сайн хэрэгжилттэй байна.

Гаднаас оруулж ирэх тоног төхөөрөмж шаардлагатай, нарийн орц технологитой үйлдвэрлэл, зөгийн аж ахуй, мод хавтан орцтой үйлдвэрлэл хангалтгүй байна.

Мөн ковид-19 цар тахлын үед хил хаагдсанаас материал таталт зогссон, гүйлгээ муудсан, үйлдвэрлэл зогссон зэргээс шалтгаалан ашиг орлогогүй болж зээлээ төлж чадахгүй байдалд хүрсэн иргэд олон байна.

Иргэд авсан зээлээрээ явуулж буй үйлдвэрлэлдээ нэмж тоног төхөөрөмж худалдан авдаг байна. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авалтад зохих хяналтыг тавьж баримтжуулдаг байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг төрөөс бизнесийн зээлийн хувьд харьцангуй өндөр 10 хүртэл сая төгрөгийн зээл олгодог боловч эргэн төлөлт муу, зээл авсан иргэд хаана яваа нь тодорхойгүй байдалтай тохиолдол ч байна.

Харин ахмад настнуудын зөвлөх үйлчилгээний зээлийн хувьд эргэн төлөлт сайтай, идэвхтэй байна.

Мөн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн зээл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зээлийн хөтөлбөр, малчдын хөдөлмөрийг дэмжих зээл зэрэг нь эргэн төлөлт харьцангуй сайн байна.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас аудитын багт зээлийн асуудлыг банкаар дамжуулан олгодог эрсдэлийг нь банк өөрөө хариуцдаг байх саналыг тавьж байсан.

Зээлийн хэрэгжилт, хөтөлбөрийн биелэлтэд багийн дарга, зохион байгуулагчид, сайн нөлөөтэй, ажиллагаа сайтай, баг дээрх хөтөлбөр сайн хэрэгждэг, зээл эргэн төлөлт сайн байгаа нь ажиглагдсан.

Товч дүгнэвэл: 5 хөтөлбөрийн үр дүнд иргэд зохих амьжиргааны эх үүсвэр, ажлын байртай болж, хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхол нэмэгдэн зохих орлого олдог болсон байна.

Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс нь хяналтыг хэрэгжүүлж, үр нөлөөг үнэлэн санал санаачилгатай, зохион байгуулалт сайтай ажиллаж байна.

Цаашид хөтөлбөрүүдийг улам боловсронгуй болгож, зээлийн хэмжээг нэмэгдүүлэн, зээл олгох тогтолцоог өөрчлөх, өөрт тохирсон бизнес эрхлэхэд туслалцаа үзүүлэх, хяналтыг улам сайжруулах шаардлагатай.

2.4 МБСДС-аас сурагчдад сар бүр олгох тэтгэлгийн хэмжээг 200.0 мянган төгрөг болгосноор суралцагчдын тоо нэмэгдсэн ч ажил эрхлэлтийн байдал хангалттай түвшинд хүрээгүй байна.

2.4.1 Сурагчдад сар бүр олгох тэтгэлгийн хэмжээг 200.0 мянган төгрөг болгосноор сурагчдын тоо нэмэгдсэн байна.

Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангаас олгосон тэтгэлгийг хүснэгтээр харуулбал:

Орхон аймгийн ХАА-н МСҮТ-ын хувьд:

/Төгрөгөөр/

№	Он	Сурагчийн тоо	Тэтгэлгийн дүн	Мөнгөн дүн
1	2016	1,635	70,000.00	95,093,901.00
2	2017	0	-	-
3	2018	0	-	-
4	2019	1,195	100,000.00	119,500,000.00
5	2020	1,692	200,000.00	336,400,000.00
6	2021	2,043	200,000.00	359,000,000.00

2019 онд давхардсан тоогоор 1,195 сурагч тэтгэлэг авч байсан бол 2020 онд 1,692 сурагч тэтгэлэг авсан байна. 2021 онд 2,043 сурагч тэтгэлэг авсан нь өмнөх оноос 351-ээр буюу 20.7 хувиар өссөн байна.

Орхон аймгийн МСҮТ-ын хувьд:

/Төгрөгөөр/

№	Он	Сурагчийн тоо	Тэтгэлгийн дүн	Мөнгөн дүн
1	2016	3,085	70,000.00	215,950,000.00
2	2017	0	-	-
3	2018	0	-	-
4	2019	2,141	100,000.00	214,100,000.00
5	2020	5,230	200,000.00	1,046,000,000.00
6	2021	5,815	200,000.00	1,163,000,000.00

2019 онд давхардсан тоогоор 2,141 сурагч тэтгэлэг авч байсан бол 2020 онд 5,230 сурагч тэтгэлэг авсан байна. 2021 онд 5,815 сурагч тэтгэлэг авсан нь өмнөх оноос 585-аар буюу 11.2 хувиар өссөн байна.

2.4.2 МСҮТ-үүдийг 2016-2022 оны хооронд суралцаж төгссөн нийт сурагчдын 58.3 хувь, насанд хүрэгчдийн 83.5 хувь нь хөдөлмөр эрхэлж байна.

Орхон аймгийн Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг 2016-2021 оны хичээлийн жилд төгссөн сурагчдын тоог хүснэгтээр харуулбал:

№	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэр	Төгсөгчдийн тоо						Дүн
		2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	
1	Орхон аймгийн МСҮТ	203	253	107	103	167	211	
2	Орхон аймгийн ХАА-н МСҮТ	149	74	31	35	42	44	
Дүн		352	327	138	138	209	255	1,419

МСҮТ-ийг төгссөн сурагчдын тоо 2018-2019, 2019-2020 онуудын хичээлийн жилд тус бүр нь 138 суралцагч төгссөн бол 2020-2021 оны хичээлийн жилд өмнөх оноос 51.4 хувиар өссөн байна. Энэ сурагч бүрд сар бүр 200.0 мянган төгрөгийн тэтгэлэг олгодог болсонтой холбоотой байна.

№	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэр	Ажил эрхлэлт						Дүн
		2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	
1	Орхон аймгийн МСҮТ	121	220	69	97	56	77	
2	Орхон аймгийн ХАА-н МСҮТ	70	31	16	18	23	29	
Дүн		191	251	85	115	79	106	827

Дээрх хүснэгтээс харахад 2016-2021 оны хичээлийн жилд суралцаж төгссөн нийт 1,419 сурагчдын 58.3 хувь нь ажил эрхэлж байна.

Насанд хүрэгчдийн сурсан байдал:

МСҮТ-үүдэд 2016 оноос 2021 оны хооронд суралцсан насанд хүрэгчдийн боловсролын түвшнийг ангилан хүснэгтээр харуулбал:

№	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэр	Боловсролын түвшин			Нийт дүн
		Бага боловсрол	Бүрэн дунд	Дээд боловсролтой	
1	Орхон аймгийн МСҮТ	153	588	266	1007
2	Орхон аймгийн ХАА-н МСҮТ	0	497	17	514
Дүн		153	1085	283	1521

Нийт суралцагсдын 10 хувь нь бага боловсролтой, 71.3 хувь нь бүрэн дунд боловсролтой, 18.7 хувь нь дээд боловсролтой байна.

МСҮТ-үүдэд 2016 оноос 2021 оны хооронд суралцсан насанд хүрэгчдийн насны ангиллыг хүснэгтээр харуулбал:

№	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэр	Насны ангилал				Нийт дүн
		20-25	25-35	40-45	45 ба түүнээс дээш	
1	Орхон аймгийн МСҮТ	507	374	126	0	1007
2	Орхон аймгийн ХАА-н МСҮТ	324	176	13	1	514
Дүн		831	550	139	1	1521

Нийт суралцагсдын 54.6 хувь нь 20-25 настай, 36.2 хувь нь 25-35 настай, 9.1 хувь 40-45 настай, 0.1 хувь нь 45-аас дээш настай байна.

МСҮТ-үүдэд 2016 оноос 2021 оны хичээлийн жилд суралцан төссөн байдлыг хүснэгтээр харуулбал:

№	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэр	Төгсөгчдийн тоо						Дүн
		2016	2017	2018	2019	2020	2021	
1	Орхон аймгийн МСҮТ	81	231	225	195	101	174	
2	Орхон аймгийн ХАА-н МСҮТ	43	24	29	67	121	0	
Дүн		124	255	254	262	222	174	1291

МСҮТ-ийг суралцаж төгссөн насанд хүрэгчдийн тоо 2016 онд 124 байсан бол 2017 онд 255 болж өмнөх оноос 131-ээр өссөн байна. Харин 2020 онд 222 болсон нь өмнөх оноос 40-өөр буурсан байна.

МСҮТ-үүдэд 2016 оноос 2022 оны хичээлийн жилд суралцан төссөн иргэдийн ажил эрхлэлтийн байдлыг хүснэгтээр харуулбал:

№	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэр	Ажил эрхлэлт						Дүн
		2016	2017	2018	2019	2020	2021	
1	Орхон аймгийн МСҮТ	60	179	171	189	94	77	
2	Орхон аймгийн ХАА-н МСҮТ	46	39	28	45	56	0	
Дүн		106	218	199	234	150	77	1078

Дээрх хүснэгтээс харахад 2016-2021 оны хичээлийн жилд суралцаж төгссөн нийт 1291 суралцагсдын 83.5 хувь нь ажил эрхэлж байна.

2.5 "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дүгнэх хугацаа хараахан болоогүй байна.

2.5.1 Цар тахлын үед ажлын байрыг хадгалах талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь үр дүнтэй хэрэгжсэн эсэхийг дүгнэх хугацаа хараахан болоогүй байна.

Засгийн газраас коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын эрсдэлийн үед татвар, нийгмийн даатгал төлөгч аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдэд дэмжлэг үзүүлэх, төсвийн үр ашигтай удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор “эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” тогтоол гаргасан.

Мөн Засгийн газрын 140 дүгээр тогтоолын хавсралтаар нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журмыг баталсан байна.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн чөлөөлөлтийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	2020 он		2021 он	
	ААНБ-ын тоо	Дүн /Мян.төгрөг/	ААНБ-ын тоо	Дүн /Мян.төгрөг/
НДШ-ийн чөлөөлөлт	1,261	8,893,495.6	1,182	2,058,258.1

Цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалсан хувийн хэвшлийн бүх аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, төрийн болон хувийн хэвшлийн бүх их дээд сургууль, төрийн бус, шашны байгууллага, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн

нэгж, гадаад улсаас Монгол Улсад суугаа элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газар, гадаад улсын болон олон улсын байгууллага тэдгээрийн салбар нэгж төлөөлөгчийн төлөөний газар зэрэг 1261 байгууллагад 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 30 өдрийн хооронд нийт 10,951,753,752.94 төгрөг, хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулсан байна.

Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч аж ахуй, нэгж байгууллагын тоог графикаар харуулбал:



Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч аж ахуй, нэгж байгууллагын тоо 2018 онд 1392 байсан бол 2019 онд өмнөх оноос 13-өөр нэмэгдсэн байна. Харин 2020 онд өмнөх оноос Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч аж ахуй, нэгж байгууллагын тоо 32-оор буурсан байна.

Нийт албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоог графикаар харуулбал:



Нийт албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо 2019 онд 29,079 байсан бол 2020 онд 28,310 болж, өмнөх оноос 769 буюу 2.6 хувь буурсан байна. Албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо 2021 онд өмнөх оноос 1320 буюу 4.7 хувиар буурсан байна.

2.5.2 Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангаас 4,607 даатгуулагчид тус бүр нь 200.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Засгийн газрын 2020 оны 114 дугаар тогтоолын 1.3⁹ дахь заалтыг Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс хэрхэн хэрэгжүүлж ажилласныг шалгалаа.

Татварын ерөнхий газрын бэлтгэсэн цахим өгөгдлийн сан болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад орсон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд “01”, “14”, “22”, “25”, “34”, “40”, “50” төрлөөр, улсын код нь “001”-ээр бүртгэгдсэн Монгол Улсын иргэн даатгуулагчид 200,000 төгрөгийн дэмжлэгийг олгосон байна.

Аж ахуйн нэгжийн дэмжлэг авах даатгуулагчийн тоог 2020 оны 2, 3 дугаар сарын аль өндөр тайлагнасан нийт даатгуулагчийн тооноос хэтрүүлэхгүйгээр тооцож олгосон байна.

2020 онд олгосон дэмжлэгийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	2020 он		
	ААНБ тоо	Даатгуулагчийн тоо	Дүн /мян.төг/
Дэмжлэг	210	4,607	921,400.0

2020 оны 04, 05, 06 дугаар сард Орхон аймгийн хэмжээнд нийт 210, давхардсан тоогоор 594 аж ахуйн нэгж байгууллагын 4,607 даатгуулагчид 921,400.0 (есөн зуун хорин нэгэн сая дөрвөн зуун мянган) төгрөгийн олголтыг тухайн байгууллагын харилцах дансанд шилжүүлэн ажилласан байна.

2.5.3 Цар тахлын үед сайн дурын даатгалд хамрагдагсдын тоо өссөн байна.

Сайн дурын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоог он оноор графикаар харуулбал:



⁹ коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан боловч ажлын байрыг хадгалж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжийн даатгуулагч Монгол Улсын иргэнд 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200 000 (хоёр зуун мянган) төгрөгийн дэмжлэг олгох;

Сайн дурын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо 2018 онд 6,800 байсан бол 2019 онд 6,270 болж, өмнөх оноос 530 буюу 7.7 хувь буурсан байна. Харин 2020 онд даатгуулагчдын тоо өмнөх оноос 395 буюу 6.2 хувиар өссөн байна.

Энэ нь Цар тахлын үед сайн дураар даатгуулагчийг шимтгэлээс чөлөөлсөнтэй холбоотой байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан хэдий ч хэрэгжилтийг бодитой үнэлээгүй, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тооцож чадаагүй байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.
- Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох үйл ажиллагаа хоорондоо уялдаагүй байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааг үр нөлөөтэй, хэмнэлттэй зохион байгуулсан байна.
- Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад, дотоодын зээл, тусламж, ОУБ-уудын санхүүжилттэй төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлсэн, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн дүнд иргэдийн амьдрал дээшилж байгаа нь тодорхойгүй, зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.
- МБСДС-аас сурагчдад сар бүр олгох тэтгэлгийн хэмжээг 200.0 мянган төгрөг болгосноор суралцагчдын тоо нэмэгдсэн ч ажил эрхлэлтийн байдал хангалттай түвшинд хүрээгүй байна.
- "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дүгнэх хугацаа хараахан болоогүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-ын даргад:

- Орхон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг бодитой үнэлж, дүгнэж байх.

Аймгийн Засаг даргад:

- Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилттой бүрэн нийцүүлэх.
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна.” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.


Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт:

- Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон үр дүнгийн судалгааг тодорхой давтамжтай, үр дүнтэй зохион байгуулах.

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР:  Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:  Т.БОЛОРМАА

АУДИТОР:  Д.ЦОГБАДРАХ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

ОРХОН АЙМГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР61040 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Баянбулаг баг, Утас: 70352353
Цахим шуудан: orkhon.hudulmur-halamj.gov.mn2022.05.05 № 0/606
танай _____ -ны № _____ -тОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх бодлогын хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангын төсөлтэй танилцлаа. Тус газраас ямар нэгэн саналгүй байна.

ДАРГА

Х.ЭРДЭНЭБАТ



D/My documents/A-5

00001107